

2019 оны 1 сарын 30 өдөр

№ 19/01

Улаанбаатар хот

ЛэндМН ББСБ ХК-ийн 2018 оны
санхүүгийн болон үйл ажиллагааны
тайлангийн талаар дүгнэлт гаргах тухай

Компанийн тухай Монгол Улсын хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.11 дахь заалт, 96 дугаар зүйл, ЛэндМН ББСБ ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн Аудитын хорооны 2019 оны 1 дүгээр сарын 30-ны өдрийн ээлжит хурлаас гаргасан дүгнэлт, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2019 оны 1 дүгээр сарын 30-ны өдрийн ээлжит хурлын шийдвэрийг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. "Эрнст энд Янг Монголиа Аудит" ХХК-ийн гаргасан 2018 оны 12 дугаар сарын 31-ний байдлаарх компанийн нэгдсэн санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтийг хүлээн зөвшөөрсүгэй.
2. ЛэндМН ББСБ ХК-ийн 2018 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг хангалттай гэж дүгнэсүгэй.
3. Энэхүү тогтоолын 2-т заасан тайланг Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд танилцуулж, зохих шийдвэрийг гаргуулахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга /О.Болдбаатар/-д даалгасугай.
4. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн Аудитын хороо /Ж.Жаргалсүрэн/-д үүрэг болгосугай.

ТУЗ-ИЙН ДАРГА



О.БОЛДБААТАР



Улаанбаатар хот

Компанийн тухай Монгол Улсын хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18 дахь заалт, 81 дугаар зүйлийн 81.5.4 дэх заалт, ЛэндМН ББСБ ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн Засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хорооны 2019 оны 1 дүгээр сарын 23-ны өдрийн хурлаас санал болгосныг Төлөөлөн удирдах зөвлөлийн 2019 оны 1 дүгээр сарын 30-ны өдрийн ээлжит хурлаар авч хэлэлцэж гаргасан шийдвэр, Гүйцэтгэх захиралтай байгуулсан Хөдөлмөрийн контрактыг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1. ЛэндМН ББСБ ХК-ийн Гүйцэтгэх захирал Б.Дэлгэржаргалын 2018 оны гүйцэтгэл, түүний үр дүнг Хавсралтаар баталсугай.

ТУЗ-ИЙН ДАРГА



О.БОЛДБААТАР

2019 оны 01 сарын 30 өдөр

№ 19/03

Улаанбаатар хот

Ногдол ашиг хуваарилах тухай

Компанийн тухай Монгол Улсын хуулийн 46 дугаар зүйл, Лэнд МН ББСБ ХК-ийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.6.8 дахь заалт, 23 дугаар зүйл, Төлөөлөн Удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журмын 2.8.8 дахь заалт, Ногдол ашгийн бодлогын 2.2 дахь хэсэг, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2019 оны 1 дүгээр сарын 30-ны өдрийн ээлжит хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1. “ЛэндМН ББСБ” ХК-ийн 2018 оны жилийн эцсийн цэвэр ашгаас тус компанийн хувьцаа эзэмшигчдэд олгох ногдол ашгийн нэгж хувьцаанд ногдох хэмжээг 1.00 (нэг) төгрөгөөр тогтоож, 2018 оны цэвэр ашгийн 31.24% буюу нийт 800,000,000 төгрөгийг ногдол ашигт хуваарилан, хүн амын орлогын албан татвар болон хуулийн этгээдийн хувьд аж ахуйн нэгжийн орлогын албан татварыг холбогдох хуулийн дагуу суутган, 2019 оны 5 дугаар сарын 1-ний өдрийн дотор мөнгөн хэлбэрээр олгосугай.
2. Ногдол ашиг авах эрхтэй тус компанийн энгийн хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2019 оны 2 дугаар сарын 22-ны өдрөөр тогтоосугай.
3. Ногдол ашиг хуваарилах шийдвэрийг хувьцаа эзэмшигчдэд хүргэх, хуваарилсан ногдол ашгийг холбогдох хууль, тогтоомжийн дагуу хувьцаа эзэмшигчдэд олгохыг Компанийн Гүйцэтгэх захиралд үүрэг болгосугай.

ТУЗ-ИЙН ДАРГА



О.БОЛДБААТАР

2019 оны 1 сарын 30 өдөр

№ 19/04

Улаанбаатар хот

Гүйцэтгэх захирлыг үүрэгт ажлаас чөлөөлөх тухай

Компанийн тухай Монгол Улсын хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.8 дахь заалт, ЛэндМН ББСБ ХК-ийн Дүрмийн 9.6.6 дахь заалт, Төлөөлөн удирдах зөвлөлийн Засаглал, нэр дэвшүүлэх, цалин үрамшууллын хорооны 2019 оны 1 дүгээр сарын 23-ны өдрийн хурлаас санал болгосныг Төлөөлөн удирдах зөвлөлийн 2019 оны 1 дүгээр сарын 30-ны өдрийн ээлжит хурлаар хэлэлцэж гаргасан шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. ЛэндМН ББСБ ХК-ийн Гүйцэтгэх захирал Б.Дэлгэржаргал (РД:ХБ73070664) нь өөр ажилд шилжин ажиллахаар өөрийн хүсэлтээр чөлөөлөгдөх хүсэлтээ гаргасныг үндэслэн түүнийг ЛэндМН ББСБ ХК-ийн Гүйцэтгэх захирлын үүрэгт ажлаас 2019 оны 1 дүгээр сарын 31-ний өдрөөр тасалбар болгон чөлөөлсүгэй.
2. Ажил хүлээлцэх, Санхүүгийн Зохицуулах Хороо, Монголын Хөрөнгийн бирж болон холбогдох бусад этгээдэд мэдээллийг хүргүүлэх, Улсын бүртгэлд бүртгүүлэх ажлыг 2019 оны 2 дугаар сарын 14-ний дотор гүйцэтгэхийг Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга /О.Мөнхдөлгөөн/-д даалгасугай.

ТУЗ-ИЙН ДАРГА



О.БОЛДБААТАР

2019 оны 1 сарын 30 өдөр

№ 16/05

Улаанбаатар хот

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг чөлөөлөх,
хараат бүс түр гишүүнийг томилох тухай

Компанийн тухай Монгол Улсын хуулийн 77 дугаар зүйлийн 77.5 дахь заалт, “ЛэндМН ББСБ” ХК-ийн Дүрмийн 9.1 дэх заалт, 11, 12 дахь хэсэг, Төлөөлөн удирдах зөвлөлийн Үйл ажиллагааны журмын 4.1 дэх хэсэг, ТУЗ-ийн Засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хорооны 2019 оны 1 дүгээр сарын 23-ны өдрийн хурлаас санал болгосныг Төлөөлөн удирдах зөвлөлийн 2019 оны 1 дүгээр сарын 30-ны өдрийн ээлжит хурлаар авч хэлэлцэж гаргасан шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бүс гишүүн Булганы Гантулга нь Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бүс гишүүнээс чөлөөлөгдөх хүсэлтээ гаргасан тул энэхүү тогтоол гарсан үеэс бүрэн эрхийг нь зогсоож, 2019 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар тус гишүүнийг чөлөөлөгдсөнийг баталгаажуулахаар тогтоосугай.
2. ТУЗ-ийн Засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хорооноос нэр дэвшүүлснийг үндэслэн Чинбатын Номинг Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бүс түр гишүүнээр томилсугай.
3. Чинбатын Номинг ЛэндМН ББСБ ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бүс гишүүнээр сонгох саналыг Хувьцаа эзэмшигчдийн 2019 оны ээлжит хуралд танилцуулж, шийдвэрлүүлсугай.
4. Хууль тогтоомж, Компанийн дүрэм, ТУЗ-ийн үйл ажиллагааны журам, компанийн засаглалын журмуудыг мөрдөж ажиллахыг шинээр томилогдсон ТУЗ-ийн хараат бүс түр гишүүнд мэдэгдсүгэй.
5. Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнд орсон өөрчлөлт, шинээр томилогдсон хараат бүс түр гишүүний талаарх мэдээллийг хувьцаа эзэмшигчид, Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн биржид мэдэгдэхийг Төлөөлөн удирдах зөвлөлийн Нарийн бичгийн дарга /О.Мөнхдөлгөөн/-д даалгасугай.

ТУЗ-ийн дарга



О.БОЛДБААТАР

2019 оны 1 сарын 30 өдөр

№ 19/06

Улаанбаатар хот

Төлөөлөн удирдах зөвлөлийн хороодын
бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай

Компанийн тухай Монгол Улсын хуулийн 81 дүгээр зүйл, "ЛэндМН ББСБ" ХК-ийн Дүрмийн 9.1 дэх заалт, Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журмын 4.1 дэх хэсэг, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2019 оны 1 дүгээр 30-ны өдрийн ээлжит хурлын шийдвэрийг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. ТУЗ-ийн гишүүдийн бүрэлдэхүүнд өөрчлөлт орж, хараат бүс түр гишүүнийг шинээр томилсонтой холбогдуулан Төлөөлөн удирдах зөвлөлийн хороодын бүрэлдэхүүнийг дараах байдлаар шинэчлэн баталсугай. Үүнд:

- а. Засаглал, нэр дэвшүүлэх болон цалин урамшууллын хороо:

Хорооны дарга:	В.Баярсайхан
Гишүүд:	Ч.Номин Ж.Жаргалсүрэн

- б. Аудитын хороо:

Хорооны дарга:	Ж.Жаргалсүрэн
Гишүүд:	О.Болдбаатар С.Боргил

- в. Эрсдэлийн удирдлагын хороо:

Хорооны дарга:	Мэтью Вэлч
Гишүүд:	С.Боргил Б.Дэлгэржаргал Н.Цэвэгмид С.Энх-Амгалан

2. Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журмыг мөрдөж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн хороодын дарга, гишүүдэд үүрэг болгосугай.

ТУЗ-ИЙН ДАРГА



О.БОЛДБААТАР

2019 оны 1 сарын 30 өдөр

№ 19/07

Улаанбаатар хот

Гүйцэтгэх захирал томилох тухай

Компанийн тухай Монгол Улсын хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.8 дахь заалт, ЛэндМН ББСБ ХК-ийн Дүрмийн 9.6.6 дахь заалт, Төлөөлөн удирдах зөвлөлийн Засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хорооны 2019 оны 1 дүгээр сарын 23-ны өдрийн хурлаас санал болгосныг Төлөөлөн удирдах зөвлөлийн 2019 оны 1 дүгээр сарын 30-ны өдрийн ээлжит хурлаар хэлэлцэж гаргасан шийдвэрийг түс түс үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Булганы Гантулга (ЦБ83050277)-ыг 2019 оны 2 дугаар сарын 1-ний өдрөөс ЛэндМН ББСБ ХК-ийн Гүйцэтгэх захирлаар томилсугай.
2. Гүйцэтгэх захирлын ажил, үүргийг хүлээлцэх арга хэмжээг ажлын 5 өдрийн дотор зохион байгуулж, хүлээн авахыг Гүйцэтгэх захирал Б.Гантулгад даалгасугай.
3. Гүйцэтгэх захирлын цалин, урамшууллыг энэхүү тогтоолын хавсралтаар баталсугай.
4. Компанийг төлөөлж Гүйцэтгэх захиралтай Хөдөлмөрийн контрактын гэрээ болон Нууцлалын гэрээ байгуулахыг ТУЗ-ийн дарга /О.Болдбаатар/-т даалгасугай.
5. Энэхүү тогтоолын биелэлтийг хангуулах, энэхүү өөрчлөлтийн талаар Санхүүгийн Зохицуулах Хороо, Монголын Хөрөнгийн бирж, Олон нийтэд мэдэгдэх болон Улсын бүртгэлийн ерөнхий газрын Хуулийн этгээдийн бүртгэлийн газарт шинэ Гүйцэтгэх захирлын мэдээллийг бүртгүүлэх ажлыг 2019 оны 2 дугаар сарын 14-ний өдрийн дотор зохион байгуулж, хэрэгжүүлэхийг Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга /О.Мөнхдөлгөөн /-д даалгасугай.

ТУЗ-ийн дарга  О.БОЛДБААТАР



2019 оны 1 сарын 30 өдөр

№ 19/08

Улаанбаатар хот

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг
зарлан хүралдуулах тухай

Компанийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.4 дэх заалт, 60 дугаар зүйл, 64 дүгээр зүйлийн 64.1, 64.2, 64.4 дэх заалт, 65 дугаар зүйл, 67 дугаар зүйлийн 67.1, 71 дүгээр зүйлийн 71.1, 71.3, 76 дугаар зүйлийн 76.1.2, 76.1.3 дахь заалт, Санхүүгийн Зохицуулах Хорооны 2018 оны 377 дугаар тогтоолоор батлагдсан "Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх, хяналт тавих журам", "ЛэндМН ББСБ" ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2018 оны 1 дүгээр сарын 30-ны өдрийн ээлжит хурлаар хэлэлцэн гаргасан шийдвэрийг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. "ЛэндМН ББСБ" ХК (цаашид "компани")-ийн Хувьцаа эзэмшигчдийн 2019 оны ээлжит хурлыг 2019 оны 3 дугаар сарын 23-ны өдрийн 12:00 цагт Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, Корпорейт Конвеншн Центрийн эвент танхимд зохион байгуулж хүралдуулахаар шийдвэрлэсүгэй.
2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дараах асуудлуудыг хэлэлцүүлэхээр оруулсугай.
 - 2.1. Компанийн 2018 оны үйл ажиллагааны болон санхүүгийн аудитлагдсан тайланг танилцуулах;
 - 2.2. Компанийн 2018 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаархи Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэн батлах;
 - 2.3. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн зарим гишүүдийг улируулан сонгох эсэх асуудал;
 - 2.4. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах, Төлөөлөн удирдах зөвлөлийн Ердийн болон Хараат бус зарим гишүүнийг сонгох тухай;
 - 2.5. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2019 оны төсвийг батлах;
 - 2.6. Компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах санал оруулах тухай;
 - 2.7. Компанийн Гүйцэтгэх удирдлага болон ажиллагчдад дунд хугацааны урамшууллын бодлогыг хэрэгжүүлэх зорилгоор Төлөөлөн удирдах зөвлөлөөс тогтоосон хэмжээ, нөхцөлөөр компанийн хувьцааг эргүүлэн худалдан авах эсэх.
3. Хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах Бүртгэлийн өдрийг 2019 оны 2 дугаар сарын 22-ны өдрөөр тогтоосугай.
4. Компанийн "Хувьцаа эзэмшигчдийн хурлын мэдэгдэл"-ийг энэхүү тогтоолын Хавсралт 1-ийн дагуу баталж, Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн бирж ХК-д 2019 оны 2 дугаар сарын 2-ны өдрийн дотор хүргүүлэхийг Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга /О.Мөнхдөлгөөн/-д үүрэг болгосугай.

5. Хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулах тухай зарыг энэхүү тогтоолын Хавсралт 2-ын дагуу баталж, 2019 оны 2 дугаар сарын 4 болон 19-ны өдрүүдэд компанийн цахим хуудас, өдөр тутмын сонин, орон даяар нэвтрүүлэг түгээдэг радио, телевиз болон Монголын хөрөнгийн биржийн цахим хуудсаар дамжуулан хувьцаа эзэмшигчдэд мэдээлэхийг хурал зохион байгуулах комисст даалгасугай.
6. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудалтай холбоотой Хувьцаа эзэмшигчдийн танилцаж болох баримт бичгийн жагсаалтыг энэхүү тогтоолын Хавсралт 3-ын дагуу баталж, баримт бичгийг 2019 оны 2 дугаар сарын 11-ний өдрийн дотор бэлтгэн хувьцаа эзэмшигчдэд үйлчилж буй брокер, дилерийн компаниудад хүргүүлж танилцах бололцоогоор хангаж ажиллахыг хурал зохион байгуулах комисст даалгасугай.
7. Хувьцаа эзэмшигч нь энэхүү тогтоолын Хавсралт 3-т заасан баримт бичгийг ажлын өдрүүдэд 09:00-17:00 цагийн хооронд Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 5-р хороо, Үндсэн хуулийн гудамж, Нью Майнд Групп ХХК-ийн байрны 1 давхарт ирж танилцаж болохыг мэдэгдсүгэй.
8. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын даргаар Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга /О.Болдбаатар/-ыг томилсугай.
9. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал зохион байгуулах комиссын дарга, гишүүдийг ЛэндМН ББСБ ХК-ийн дараахь ажилтны бүрэлдэхүүнтэйгээр томилсугай. Үүнд:
 - 9.1. Комиссын дарга:

Б.Гантулга	ЛэндМН ББСБ ХК, Гүйцэтгэх захирал
------------	-----------------------------------
 - 9.2. Гишүүд:

М.Отгонтулгалаг	ЛэндМН ББСБ ХК, Маркетингийн албаны менежер
Ж.Нацагдорж	ЛэндМН ББСБ ХК, Маркетингийн менежер
Г.Мөнх-Эрдэнэ	ЛэндМН ББСБ ХК, Бүтээгдэхүүн хөгжүүлэлтийн менежер
О.Мөнхдөлгөөн	ЛэндМН ББСБ ХК, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга
О.Батзаяа	ЛэндМН ББСБ ХК, Харилцагчийн үйлчилгээний төвийн менежер
О.Амгаланбаяр	ЛэндМН ББСБ ХК, Мэдээллийн технологи, дэд бүтцийн албаны менежер
Э.Эрэлхэгзориг	ЛэндМН ББСБ ХК, Мэдээллийн технологийн инженер
Г.Уранчимэг	Анд Системс Тех ХХК, төслийн менежер
О.Цэвээндорж	Анд Системс Тех ХХК, Системийн ахлах инженер
10. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын дарга, гишүүдийг дараах бүрэлдэхүүнтэйгээр томилсугай. Үүнд:
 - 10.1. Комиссын дарга:

М.Түвшинжаргал	ЛэндМН ББСБ ХК, Санхүү, үйл ажиллагаа хариуцсан дэд захирал
----------------	---
 - 10.2. Гишүүд:

Д.Мөнхбилгүүн	ЛэндМН ББСБ ХК, Санхүүгийн шинжээч
---------------	------------------------------------

Д.Отгонгэрэл	ЛэндМН ББСБ ХК, Ерөнхий нягтлан бодогч
Б.Тэмүгэ	ЛэндМН ББСБ ХК, Дотоод аудитор
О.Цээсүрэн	ЛэндМН ББСБ ХК, Бүтээгдэхүүн хөгжүүлэлтийн менежер

11. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын хэлэлцэх асуудлаар гарах шийдвэрийн төсөлд хувьцаа эзэмшигчдээс саналын хуудсаар санал авч, түүнийг үндэслэн хурлын тогтоолыг гаргахыг Хурлын даргад үүрэг болгосугай.
12. Хувьцаа эзэмшигчдийн хурлын дэгийг энэхүү тогтоолын Хавсралт 4-ийн дагуу, санал авах хуудсыг Хавсралт 5а, 5б, 5в-ын дагуу тус тус баталсугай.
13. Хувьцаа эзэмшигчдийн хурлын саналын хуудсыг брокер, дилерийн компаниудаар дамжуулан хувьцаа эзэмшигчдээс хэлэлцэх асуудлаар гарах шийдвэрт санал авах ажлыг зохион байгуулахыг Хурал зохион байгуулах комисст үүрэг болгож, тэдгээр саналын хуудсыг хүлээн авах эцсийн хугацааг 2019 оны 3 дугаар сарын 15-ны өдрийн 18.00 цагаар тасалбар болгохоор тогтоосугай.
14. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хүралдуулахтай холбогдон гарах зардлын төсвийн баталж, санхүүжүүлэхийг Гүйцэтгэх захирал /Б.Гантулга/-д зөвшөөрсүгэй.
15. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга /О.Мөнхдөлгөөн/, Хурал зохион байгуулах комисст тус тус үүрэг болгосугай.

ТУЗ-ийн дарга



О.БОЛДБААТАР

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН МЭДЭГДЭЛ

Компанийн нэр:	“ЛэндМН ББСБ” ХК
Хаяг, утас:	Сүхбаатар дүүрэг, 5-р хороо, Нью Майнд Групп ХХК-ийн байр
Хурал хуралдах өдөр, цаг:	2019 оны 3 сарын 23-ны өдөр 12:00 цаг
Хурал хуралдах газар: /хаяг, байршил/	Хан-Уул дүүрэг, Корпорейт Конвеншн Центр, эвент танхим
Хурлын төрөл:	Ээлжит
Хурал зарлагч:	ЛэндМН ББСБ ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл
Хурал хуралдах шийдвэр гаргасан огноо:	2019 оны 1 дүгээр сарын 30-ны өдөр
Олон нийтэд зарлах огноо:	2019 оны 2 дугаар сарын 4-ний өдөр
Бүртгэлийн өдөр:	2019 оны 2 дугаар сарын 22-ны өдөр
Гэрээний дагуу хурлын баримт, бичгийг брокер, дилерийн компанид хүргүүлэх огноо:	2019 оны 2 дугаар сарын 15-ны өдөр
Хүргүүлсэн огноо:	2019 оны 2 дугаар сарын 02-ны өдөр
Хурлын дарга:	Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга О.Болдбаатар
Тооллогын комиссын дарга:	- ЛэндМН ББСБ ХК, Санхүү, үйл ажиллагаа хариуцсан дэд захирал М.Түвшинжаргал
Гишүүд:	- ЛэндМН ББСБ ХК, Санхүүгийн шинжээч Д.Мөнхбилгүүн
	- ЛэндМН ББСБ ХК, Ерөнхий нягтлан бодогч Д.Отгонгэрэл
	- ЛэндМН ББСБ ХК, Дотоод аудитор Б.Тэмүгэ
	- ЛэндМН ББСБ ХК, Бүтээгдэхүүн хөгжүүлэлтийн менежер О.Цээсүрэн
Баримт, бичгийн жагсаалт: (хавсралтаар)	- “ЛэндМН ББСБ” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулах тухай 2019 оны 1 сарын 30-ны өдрийн 19/08 тоот Төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоол; - Хувьцаа эзэмшигчдийн хурлын зарын загвар; - Хувьцаа эзэмшигчдийн хуралдааны дэг; - “ЛэндМН ББСБ” ХК-ийн 2018 оны үйл ажиллагааны тайлан; - “ЛэндМН ББСБ” ХК-ийн 2018 оны санхүүгийн аудитлагдсан тайлан; - “ЛэндМН ББСБ” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүнд нэр дэвшигчийн

	танилцуулга; - “ЛэндМН ББСБ” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнд нэр дэвшигчийн танилцуулга; - Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2019 оны төсвийн санал; - Компаний дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах санал; - Компанийн хувьцаа халааслах санал оруулах тухай 2019 оны 1 сарын 30-ны өдрийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 19/10 тоот тогтоол - Хувьцаа эзэмшигчдийн хурлын саналын хуудасны загварууд.
Баримт, бичгийн хуудсын тоо	- ____ хуудас

ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ
КОММИССЫН ДАРГА



Б.ГАНТУЛГА

2019 оны 2 дугаар сарын 04-ний өдөр

**“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ
ХУРЛЫН ЗАР**

Компанийн нэр:	“ЛэндМН ББСБ” ХК
Хаяг, утас:	Сүхбаатар дүүрэг, 5-р хороо, Нью Майнд Групп ХХК-ийн байр
Хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдах өдөр, цаг:	2019 оны 3 сарын 23-ны өдөр 12:00 цаг
Хурал хуралдах газар: /хаяг, байршил/	Хан-Уул дүүрэг, Корпорейт Конвеншн Центр, эвент танхим
Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдөр:	2019 оны 2 дугаар сарын 22-ны өдөр
Хувьцаа эзэмшигчдийн хурлын хэлэлцэх асуудал:	1. Компанийн 2018 оны үйл ажиллагааны болон санхүүгийн аудитлагдсан тайланг танилцуулах; 2. Компанийн 2018 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаархи Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэн батлах; 3. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн зарим гишүүдийг улируулан сонгох эсэх асуудал; 4. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах, Төлөөлөн удирдах зөвлөлийн Ердийн болон Хараат бүс зарим гишүүнийг сонгох тухай; 5. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2019 оны төсвийг батлах; 6. Компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах санал оруулах тухай; 7. Компанийн Гүйцэтгэх удирдлага болон ажиллагчдад дунд хугацааны урамшууллын бодлогыг хэрэгжүүлэх зорилгоор Төлөөлөн удирдах зөвлөлөөс тогтоосон хэмжээ, нөхцөлөөр компанийн хувьцааг эргүүлэн худалдан авах эсэх.
Хувьцаа эзэмшигчдийн хурлаас гарах шийдвэрийн төсөл, түүнтэй холбогдох баримт бичигтэй танилцах журам, газар, ажиллах цаг:	Хувьцаа эзэмшигчид 2019 оны 2 дугаар сарын 11-ний өдрөөс 2019 оны 3 дугаар сарын 22-ны өдрийн хооронд өөрийн үйлчлүүлдэг үнэт цаасны компанидаа хандан, эсхүл компанийн байранд ирж хурлын баримт бичигтэй танилцаж болно. Хурал зохион байгуулах комисс нь Даваа-Баасан гаригт 09:00-13:00, 14:00-17:00 цагийн хооронд ажиллана.

Хурал зохион байгуулах комиссын дарга, гишүүдийн мэдээлэл:	- “ЛэндМН ББСБ” ХК-ийн Гүйцэтгэх захирал Б.Гантулга, gantulga@lend.mn - “ЛэндМН ББСБ” ХК-ийн Маркетингийн албаны менежер М.Отгонтунгалаг, otgontungalag@lend.mn - “ЛэндМН ББСБ” ХК-ийн Маркетингийн албаны менежер Ж.Нацагдорж, natsagdorj@lend.mn - “ЛэндМН ББСБ” ХК-ийн Бүтээгдэхүүн хөгжүүлэлтийн менежер Г.Мөнх-Эрдэнэ, munkherdene@lend.mn - “ЛэндМН ББСБ” ХК-ийн Харилцагчийн үйлчилгээний төвийн менежер О.Батзаяа, batzaya@lend.mn - “ЛэндМН ББСБ” ХК-ийн Мэдээллийн технологи, дэд бүтцийн албаны менежер О.Амгаланбаяр, amgalanbayar@lend.mn - “ЛэндМН ББСБ” ХК-ийн Мэдээллийн технологийн инженер Э.Эрэлхэгзориг, erelkhegzorig@lend.mn - “ЛэндМН ББСБ” ХК-ийн ТУЗ-ийн нарийн бичгийн дарга О.Мөнхдөлгөөн, munkhdulguun@lend.mn
---	---

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИСС

**ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛААР ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛТАЙ ХОЛБООТОЙ
ТАНИЛЦАЖ БОЛОХ БАРИМТ БИЧГИЙН ЖАГСААЛТ**

	Баримт бичгийн жагсаалт
1	- “ЛэндМН ББСБ” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулах тухай Төлөөлөн удирдах зөвлөлийн 2019 оны 1 сарын 30-ны өдрийн 19/08 тоот тогтоол;
2	- Хувьцаа эзэмшигчдийн хурлын зар;
3	- Хувьцаа эзэмшигчдийн хуралдааны дэг;
4	- Хувьцаа эзэмшигчдийн хурлын саналын хуудас;
5	- “ЛэндМН ББСБ” ХК-ийн 2018 оны үйл ажиллагааны тайлан;
6	- “ЛэндМН ББСБ” ХК-ийн 2018 оны санхүүгийн тайлан, аудитын дүгнэлт;
7	- “ЛэндМН ББСБ” ХК-ийн 2018 оны санхүүгийн болон үйл ажиллагааны тайланг дүгнэсэн тухай Төлөөлөн удирдах зөвлөлийн 2019 оны 1 сарын 30- ны өдрийн 19/01 тоот тогтоол;
8	- “ЛэндМН ББСБ” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүний танилцуулга;
9	- “ЛэндМН ББСБ” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүнд нэр дэвшигчийн танилцуулга;
10	- “ЛэндМН ББСБ” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнд нэр дэвшигчийн танилцуулга;
11	- “ЛэндМН ББСБ” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2019 оны төсвийн санал;
12	- “ЛэндМН ББСБ” ХК-ийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах санал;
13	- Компанийн хувьцаа халааслах санал оруулах тухай Төлөөлөн удирдах зөвлөлийн 2019 оны 1 сарын 30-ны өдрийн 19/10 тоот тогтоол;
14	- Хувьцаа эзэмшигчдийн хурлаас гарах шийдвэрийн төсөл;
15	- Хувьцаа эзэмшигчдийн хурлын нэмэлт материал.

**“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ
ХУРЛЫН ДЭГ**

No	Хэлэлцэх асуудал	Хугацаа	Хариуцах
1	Хурлын ирц бүртгэх	11:30-12:00	Тооллогын комисс
2	Хурлын ирцийг мэдээлэх	12:00-12:05	Тооллогын комисс
3	Хурлыг нээх, хурлын дэг танилцуулах	12:05-12:15	Хурлын дарга
4	Компанийн 2018 оны үйл ажиллагааны болон санхүүгийн аудитлагдсан тайланг танилцуулах	12:15-12:30	Гүйцэтгэх захирал
5	Компанийн ТУЗ-ийн тайлан, 2018 оны үйл ажиллагааны болон санхүүгийн аудитлагдсан тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэх	12:30-12:45	ТУЗ-ийн дарга
6	Компанийн ТУЗ-ийн зарим гишүүдийг улируулан сонгох саналыг танилцуулах	12:45-13:00	ТУЗ-ийн дэргэдэх Засаглал, нэр дэвшүүлэх болон цалин, урамшууллын хорооны дарга
7	Компанийн ТУЗ-ийн ердийн болон хараат гишүүнд нэр дэвшигчдийг танилцуулах	13:00-13:15	ТУЗ-ийн дэргэдэх Засаглал, нэр дэвшүүлэх болон цалин, урамшууллын хорооны дарга
8	Компанийн ТУЗ-ийн 2019 оны төсвийн саналыг танилцуулах	13:15-13:30	Гүйцэтгэх захирал
9	Компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах саналыг танилцуулах	13:30-13:45	ТУЗ-ийн дарга
10	Компанийн хувьцаа халааслах саналыг танилцуулах	13:45-14:00	ТУЗ-ийн дарга
11	Хэлэлцэж байгаа асуудлуудтай холбогдсон асуулт, хариулт	14:00-14:20	Хурлын дарга

12	Хэлэлцэж байгаа асуудлуудаар санал хураах	14:20-14:40	Хурлын дарга, Тооллогын комисс
13	Санал хураалтын дүнг танилцуулж, тооллогын комиссын тогтоолыг батлуулах	15:00-15:15	Тооллогын комиссын дарга
14	Хурлаас гарах шийдвэрийн төсөлд Хувьцаа эзэмшигчдийн санал хураалтын дүнг тусган, танилцуулж, батлуулах	15:15-15:30	Хурлын дарга, Хурал зохион байгуулах комиссын дарга
15	Хурлыг хаах	15:30-15:40	Хурлын дарга

**“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН
САНАЛ АВАХ ХУУДАС**

Хувьцаа эзэмшигчийн овог, нэр: _____
Регистрийн дугаар: _____
Эзэмшиж буй хувьцааны төрөл: _____ Энгийн
Эзэмшиж буй хувьцааны тоо (ширхэг): _____
Үнэт цаасны дансны дугаар: _____
Бүртгэсэн ҮЦК-ийн нэр: _____
Брокерийн овог, нэр: _____

№	Хэлэлцэн батлах асуудал	Хувьцаа эзэмшигчийн санал			
		Зөвшөөрсөн	Татгалзсан	Түдгэлзсэн	Татгалзсан бол таны өгөх санал
1	Компанийн 2018 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг батлах				
2	Төлөөлөн удирдах зөвлөлийн 2019 оны төсвийг батлах				
3	Компанийн дүрмийн 2.2-т “Компанийн төв байр дараах хаягт оршин байрлана: Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 3-р хороо, Жүүлчны гудамж-34 хаягт байрлах Сүвд төв, 101 болон 201 тоот” гэж өөрчлөлт оруулах				
4	Компанийн дүрмийн 4.2-т “4.2.1. зээл; 4.2.2. факторингийн үйлчилгээ; 4.2.3. төлбөрийн баталгаа гаргах; 4.2.4. төлбөр тооцооны хэрэгсэл гаргах; 4.2.5. цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ;				

	4.2.6. гадаад валютын арилжаа; 4.2.7. итгэлцлийн үйлчилгээ; 4.2.8. богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх; 4.2.9. хөрөнгө оруулалт, санхүүгийн чиглэлээр зөвлөгөө, мэдээлэл өгөх. 4.2.10. үл хөдлөх эд хөрөнгө барьцаалахтай холбоотой санхүүгийн зуучлалын үйл ажиллагаа” гэж өөрчлөлт оруулах				
5.	Компанийн нийт гаргасан хувьцааны 0.5%-тай тэнцэх буюу 4,000,000 (дөрвөн сая) ширхэг хувьцааг удирдлагын болон ажиллагчдад дунд хугацааны урамшууллын бодлогыг хэрэгжүүлэх зорилгоор халааслан, эргүүлэн худалдан авах				

Хувьцаа эзэмшигч иргэн:

Гарын үсэг: _____

Хувьцаа эзэмшигч хуулийн этгээдийг төлөөлж хуралд оролцсон төлөөлөгч:

Гарын үсэг: _____
 Албан тушаал: _____

Брокерийн гарын үсэг (тамга): _____

Саналын хуудас хүлээн авсан огноо, цаг: _____

Саналын хуудсыг хүчинтэйд тооцон тоолсон

Тооллогын комиссын Дарга: _____
 Гишүүн: _____
 Гишүүн: _____

Хэрэв хүчингүйд тооцсон бол шалтгаан: _____

Санал авах хуудас ашиглах дараахь санамжтай танилцана уу!

Санал авах хуудас ашиглах санамж

1. Хувьцаа эзэмшигч нь саналын хуудсыг бөглөхдөө санал өгөх хэсэгтээ (+) тэмдэглэгээ хийнэ. Жишээ нь: Зөвшөөрсөн бол зөвшөөрсөн гэсэн нүдэнд (+), татгалзсан, эсхүл түдгэлзсэн бол харгалзах нүдэнд (+) тэмдэг тавина.
2. Санал авах хуудасны эхний хэсгийг зүүчлагч үнэт цаасны компанийн тэмдэг даран баталгаажуулж хувьцаа эзэмшигчдэд өгнө.
3. Засварласан, балласан болон залруулгатай санал авах хуудас нь хүчингүйд тооцогдоно.
4. Хувьцаа эзэмшигчид нь 2019 оны 3 дугаар сарын 15-ны өдрийн дотор хурлын материалтай танилцах бөгөөд хэрэв Та хуралд өөрийн биеэр оролцох боломжгүй бол санал авах хуудсанд саналаа тэмдэглэн, үйлчлүүлдэг үнэт цаасны компанидаа 2019 оны 3 дугаар сарын 15-ны өдрийн 18.00 цагаас өмнө хүргүүлнэ.
5. Хэрэв Та саналаа итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр төлөөлүүлэх бол итгэмжлэгдсэн этгээдийн мэдээллийг дор бичин итгэмжлэлийн хамт саналын хуудсыг ирүүлнэ үү.

Таныг төлөөлөх итгэмжлэгдсэн төлөөлөгчийн мэдээлэл

Итгэмжлэгдсэн төлөөлөгчийн овог, нэр: _____

Итгэмжлэгдсэн төлөөлөгчийн регистрийн дугаар: _____

Хувьцаа эзэмшигч буюу таны нэр: _____

Таны эзэмшиж буй хувьцааны тоо (ширхэг): _____

Гарын үсэг: _____

**“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН
САНАЛ АВАХ ХУУДАС**

Хувьцаа эзэмшигчийн овог, нэр: _____
Регистрийн дугаар: _____
Итгэмжлэгдсэн төлөөлөгч оролцож байгаа бол:
Итгэмжлэгдсэн төлөөлөгчийн овог, нэр, регистрийн дугаар: _____
Эзэмшиж буй хувьцааны төрөл: **Энгийн**
Эзэмшиж буй хувьцааны тоо (ширхэг): _____
Санал хураах арга: **Кумулятив**

Тайлбар: ТУЗ-ийн гишүүнийг улируулан сонгож, бүрэн эрхийн хугацааг сунгахад таны өгөх нийт саналын эрхийн тоо нь эзэмшиж буй хувьцааны тоог улируулан сонгох ТУЗ-ийн гишүүдийн тоо (7)-оор үржүүлсэнтэй тэнцэх бөгөөд энэхүү тоо нь үүнээс их болон бага байх тохиолдолд таны санал хүчингүйд тооцогдохыг анхаарна уу.

Кумулятив аргаар санал хураах жишээ:

Хэрэв та 100 ширхэг хувьцаа эзэмшдэг бол таны өгөх нийт санал нь ТУЗ-ийн улируулан сонгох гишүүдийн тоо буюу 7-г таны эзэмшиж буй хувьцааны тоо буюу 100-аар үржүүлж нийт 700 саналын эрхтэй. Үүний 500 саналын эрхийг ТУЗ-ийн ердийн 5 гишүүнд, 200 саналын эрхийг ТУЗ-ийн хараат бүс 2 гишүүнд тус тус 2 хувааж өгнө. Гэхдээ 500 саналын эрхээ ТУЗ-ийн ердийн 5 гишүүнд хувааж өгч болохоос гадна, тодорхой нэг эсвэл хэд хэдэн гишүүнд хуваан өгч болно. Мөн 200 саналын эрхээ ТУЗ-ийн 2 хараат бүс гишүүнд хувааж өгч болохоос гадна, тодорхой нэг эсвэл 2 гишүүнд хуваан өгч болно. Харин таны нийт саналын эрхийн тоо 700-с их буюу бага байж болохгүй.

№	Хэлэлцэх асуудал	Хурлаас гарах шийдвэрийн төсөл	Саналын эрхийн тоо
1	ТУЗ-ийн ердийн гишүүнийг улируулан сонгож, бүрэн эрхийн хугацааг 1 (нэг) жилээр сунгах	ТУЗ-ийн ердийн гишүүн Очирсүрэнгийн БОЛДБААТАР	
		ТУЗ-ийн ердийн гишүүн Володягийн БАЯРСАЙХАН	
		ТУЗ-ийн ердийн гишүүн Баянжаргалын ДЭЛГЭРЖАРГАЛ	
		ТУЗ-ийн ердийн гишүүн Нармандахын ЦЭВЭГМИД	
		ТУЗ-ийн ердийн гишүүн Сэнгээгийн ЭНХ-АМГАЛАН	
2	ТУЗ-ийн хараат бүс гишүүнийг улируулан сонгож, бүрэн эрхийн хугацааг 1 (нэг) жилээр сунгах	ТУЗ-ийн хараат бүс гишүүн Сүрэнхүүгийн БОРГИЛ	
		ТУЗ-ийн хараат бүс гишүүн Жигдэнгийн ЖАРГАЛСҮРЭН	
3	Нийт саналын эрхийн тоо		

Хувьцаа эзэмшигч иргэн:

Гарын үсэг: _____

Хувьцаа эзэмшигч хуулийн этгээдийг
төлөөлж хуралд оролцсон төлөөлөгч:

Гарын үсэг: _____

Албан тушаал: _____

Саналын хуудас хүлээн авсан гарын үсэг (тамга): _____

Саналын хуудас хүлээн авсан огноо, цаг: _____

Саналын хуудсыг хүчинтэйд тооцон тоолсон

Тооллогын комиссын Дарга: _____

Гишүүн: _____

Гишүүн: _____

Хэрэв хүчингүйд тооцсон бол шалтгаан: _____

"ЛЭНДМН ББСБ" ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН САНАЛ АВАХ ХУУДАС

Хувьцаа эзэмшигчийн овог, нэр: _____
 Регистрийн дугаар: _____
 Итгэмжлэгдсэн төлөөлөгч оролцож байгаа бол: _____
 Итгэмжлэгдсэн төлөөлөгчийн овог, нэр, регистрийн дугаар: _____
 Эзэмшиж буй хувьцааны төрөл: **Энгийн**
 Эзэмшиж буй хувьцааны тоо (ширхэг): _____
 Санал хураах арга: **Кумулятив**

Тайлбар: ТУЗ-ийн гишүүн сонгоход таны өгөх нийт саналын эрхийн тоо нь эзэмшиж буй хувьцааны тоог ТУЗ-ийн шинээр сонгох гишүүдийн тоо (2)-оор үржүүлсэнтэй тэнцэх бөгөөд энэхүү тоо нь үүнээс их болон бага байх тохиолдолд таны санал хүчингүйд тооцогдохыг анхаарна уу.

Кумулятив аргаар санал хураах жишээ:

Хэрэв та 100 ширхэг хувьцаа эзэмшдэг бол таны өгөх нийт санал нь шинээр сонгох ТУЗ-ийн гишүүдийн тоо буюу 2-ыг таны эзэмшиж буй хувьцааны тоо буюу 100-аар үржүүлж нийт 200 саналын эрхтэй. Үүний 100 саналын эрхийг ТУЗ-ийн ердийн гишүүнээр сонгогдох нэр дэвшигчид, 100 саналын эрхийг ТУЗ-ийн хараат бус гишүүнээр сонгогдох нэр дэвшигчид 2 хувааж өгнө. 100 саналын эрхээ ТУЗ-ийн хараат бус гишүүнд 1 нэр дэвшигчид хувааж өгч болохоос гадна, тодорхой нэг эсвэл хэд хэдэн нэр дэвшигчид хуваан өгч болно. Харин таны нийт саналын эрхийн тоо 200-с их буюу бага байж болохгүй.

№	Хэлэлцэх асуудал	Хурлаас гарах шийдвэрийн төсөл	Саналын эрхийн тоо
1	ТУЗ-ийн ердийн гишүүн сонгох	ТУЗ-ийн ердийн гишүүнээр Мэтью ВЭЛЧИЙГ сонгосугай.	
2	ТУЗ-ийн хараат бус гишүүн сонгох	ТУЗ-ийн хараат бус гишүүнээр Чинбатын НОМИНГ сонгосугай.	
		ТУЗ-ийн хараат бус гишүүнээр _____-ны _____-ийг сонгосугай.	
		ТУЗ-ийн хараат бус гишүүнээр _____-ны _____-ийг сонгосугай.	
		ТУЗ-ийн хараат бус гишүүнээр _____-ны _____-ийг сонгосугай.	
3	Нийт саналын эрхийн тоо		

Хувьцаа эзэмшигч иргэн:

Гарын үсэг: _____

Хувьцаа эзэмшигч хуулийн этгээдийг
төлөөлж хуралд оролцсон төлөөлөгч:

Гарын үсэг: _____

Албан тушаал: _____

Саналын хуудас хүлээн авсан гарын үсэг (тамга): _____

Саналын хуудас хүлээн авсан огноо, цаг: _____

Саналын хуудсыг хүчинтэйд тооцон тоолсон

Тооллогын комиссын Дарга: _____

Гишүүн: _____

Гишүүн: _____

Хэрэв хүчингүйд тооцсон бол шалтгаан: _____

20... оны ... сарын ... өдөр

№ 19/09

Улаанбаатар хот

Дүрэмд өөрчлөлт оруулах
санал оруулах тухай

Компанийн тухай Монгол Улсын хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.15 дахь заалт, "ЛэндМН ББСБ" ХК-ийн дүрмийн 9.6.22 дахь заалт, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2019 оны 1 дүгээр сарын 30-ны өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1. ЛэндМН ББСБ ХК-ийн дүрэмд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийг энэхүү тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсугай.
2. Дүрэмд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийг Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд танилцуулж, шийдвэрлүүлэхийг Компанийн Гүйцэтгэх захирал /Б.Гантулга/-д даалгасугай.

ТУЗ-ИЙН ДАРГА



О.БОЛДБААТАР

2019 оны 1 сарын 30 өдөр

№ 19/10

Улаанбаатар хот

Компанийн хувьцаа халааслах
санал оруулах тухай

Компанийн тухай Монгол Улсын хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.12, 62.1.15 дахь заалт, "ЛэндМН ББСБ" ХК-ийн дүрмийн 9.6.14, 9.6.15 дахь заалт, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2019 оны 1 дүгээр сарын 30-ны өдрийн хурлын шийдвэрийг түс түс үндэслэн ТОГТООХ нь:

1. ЛэндМН ББСБ ХК-ийн гүйцэтгэх удирдлагын болон ажиллагчдын дунд хугацааны урамшууллын бодлогыг хэрэгжүүлэх зорилгоор Компанийн нийт гаргасан хувьцааны 0.5 (тэг бүхэл аравны тав) хувь буюу 4,000,000 (дөрвөн сая) ширхэг хувьцааг халааслан, эргүүлэн худалдан авах саналыг Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд танилцуулан шийдвэрлүүлэхээр тогтоосугай.
2. Компанийн эргүүлэн худалдаж авах хувьцаа нь зөвхөн Компанийн хүний нөөцийн бодлогын хүрээнд Гүйцэтгэх удирдлага болон ажиллагчдад олгох нөхцөлтэй болохыг дүрьдсугай.
3. Гүйцэтгэх удирдлага болон ажиллагчдад хувьцаа эзэмшүүлэх бодлогыг боловсруулан, батлуулахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн Засаглал, нэр дэвшүүлэх болон цалин урамшууллын хороо /В.Баярсайхан/-д даалгасугай

ТУЗ-ИЙН ДАРГА  О.БОЛДБААТАР



2019 оны 1 сарын 30 өдөр

№ 19/11

Улаанбаатар хот

Компанийн 2019 оны үйл ажиллагааны
төлөвлөгөө, төсөв батлах тухай

Компанийн тухай Монгол Улсын хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18 дахь заалт,
“ЛэндМН ББСБ” ХК-ийн дүрмийн 9.6.1 дэх заалт, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2019 оны
1 дүгээр сарын 30-ны өдрийн ээлжит хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1. “ЛэндМН ББСБ” ХК-ийн 2019 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг энэхүү тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсугай.
2. “ЛэндМН ББСБ” ХК-ийн 2019 оны үйл ажиллагааны төсвийг энэхүү тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсугай.
3. Компанийн үйл ажиллагааны төлөвлөгөө, төсвийн зорилтыг хэрэгжүүлж ажиллах, Компанийн санхүүгийн гүйцэтгэлтэй уялдуулан үйл ажиллагааны төсөвт өөрчлөлт, оруулан, тодотгох саналыг 2019 оны эхний хагас жилд багтаан боловсруулж, шийдвэрлүүлэхийг Гүйцэтгэх захирал /Б.Гантулга/-д даалгасугай.

ТУЗ-ИЙН ДАРГА



О.БОЛДБААТАР

2019 оны 1 сарын 30 өдөр

№ 19/12

Улаанбаатар хот

Компанийн 2019 оны эх үүсвэрийн
төлөвлөгөөг батлах тухай

“ЛэндМН ББСБ” ХК-ийн дүрмийн 9.6.4, 9.6.5 дахь заалт, Төлөөлөн удирдах зөвлөлийн Эрсдэлийн удирдлагын хорооны 2019 оны 1 дүгээр сарын 30-ны өдрийн хурлаас гарсан зөвлөмж, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2019 оны 1 дүгээр сарын 30-ны өдрийн хурлын шийдвэр, Компанийн Санхүүгийн эрсдэлийн удирдлагын бодлогыг тус тус үндэслэн Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс ТОГТООХ НЬ:

1. “ЛэндМН ББСБ” ХК-ийн 2019 оны эх үүсвэрийн төлөвлөгөөг энэхүү тогтоолын 1 дугаар хавсралтаар баталсугай.
2. Энэхүү тогтоолоор батлагдсан компанийн 2019 оны эх үүсвэрийн төлөвлөгөөний дагуу Хавсралтад заасан хэмжээний хүрээнд өрийн бичиг гаргах, хөрөнгө итгэмжлэн удирдах, арилжааны эх үүсвэр татах, түүнтэй холбоотой гэрээ, хэлцэл байгуулахыг Компанийн Гүйцэтгэх захирал /Б.Гантулга/-д зөвшөөрсүгэй.
3. Компанийн эх үүсвэрийн 2019 оны эх үүсвэрийн төлөвлөгөө, энэхүү тогтоолын Хавсралтад заасан хэмжээ, жишиг нөхцөлөөс давсан болон хоёрдогч эх үүсвэрийн санал, Компанийн тухай хуулийн дагуу тогтоосон их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцлийг Төлөөлөн удирдах зөвлөлөөр батлуулсны үндсэн дээр байгуулахыг Гүйцэтгэх захирал /Б.Гантулга/-д даалгасугай.
4. Эх үүсвэрийн төлөвлөгөөний гүйцэтгэл, татан төвлөрүүлсэн эх үүсвэрийн талаарх мэдээллийг Төлөөлөн удирдах зөвлөлийн Эрсдэлийн удирдлагын хороонд тогтмол тайлагнахыг Гүйцэтгэх захирал /Б.Гантулга/-д үүрэг болгосугай.

ТУЗ-ИЙН ДАРГА



О.БОЛДБААТАР

20.19 оны 1 сарын 30 өдөр

№ 10/13

Улаанбаатар хот

Компанийн Санхүүгийн эрсдэлийн
удирдлагын бодлого батлах тухай

Компанийн тухай Монгол Улсын хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.13 дахь заалт, "ЛэндМН ББСБ" ХК-ийн дүрмийн 9.6.5, 9.6.17, 9.7 дахь заалт, Төлөөлөн удирдах зөвлөлийн Эрсдэлийн удирдлагын хорооны 2019 оны 1 дүгээр сарын 30-ны өдрийн хурлаас гарсан зөвлөмж, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2019 оны 1 дүгээр сарын 30-ны өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс ТОГТООХ НЬ:

1. "ЛэндМН ББСБ" ХК-ийн Санхүүгийн эрсдэлийн удирдлагын бодлогыг энэхүү тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсугай.
2. Санхүүгийн эрсдэлийн удирдлагын бодлого батлагдсантай холбогдуулан, Компанийн Гүйцэтгэх захиралд дараахь эрх олгосныг дурьдсугай.
 - 2.1.1. Эх үүсвэрийн жилийн төлөвлөгөөгөөр батлагдсан нөхцөл, хэмжээний хүрээнд компанийн өрийн бичиг гаргах, хөрөнгө оруулагчид санал тавих, Өрийн бичиг худалдах, худалдан авах гэрээ байгуулах;
 - 2.1.2. Эх үүсвэрийн жилийн төлөвлөгөөгөөр батлагдсан нөхцөл, хэмжээний хүрээнд хөрөнгө итгэмжлэн удирдах саналыг боломжит байгууллага, иргэдэд тавих, Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээг байгуулах;
 - 2.1.3. Өрийн бичиг, итгэлцлийн эх үүсвэрийг андеррайтер, хөрөнгө оруулалтын сан, бусад дундын зүүчлалын этгээдээр дамжуулан татсан бол тэдгээртэй холбогдох үйлчилгээний гэрээ байгуулах, ажлын үр дүнг үндэслэн шимтгэл, хөлс төлөх;
 - 2.1.4. Эх үүсвэрийн жилийн төлөвлөгөөнд заасан хэмжээнд дотоодын болон гадаадын банк, санхүү, хөрөнгө оруулалтын сан, бусад зээл, санхүүжилт олгогч байгууллагуудтай хэлэлцээр хийх, Компанийн дүрэм, Төлөөлөн удирдах зөвлөлөөс олгосон эрх, хэмжээний хүрээнд зээл авах шийдвэр гаргах, зээлийн гэрээ байгуулах.
3. Санхүүгийн эрсдэлийн удирдлагын бодлогыг хэрэгжүүлж ажиллах, шаардлагатай өөрчлөлтийн саналыг Төлөөлөн удирдах зөвлөлд танилцуулж, шийдвэрлүүлэхийг Компанийн Гүйцэтгэх захирал /Б.Гантулга/-д даалгасугай.
4. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг ТУЗ-ийн Эрсдэлийн удирдлагын хороо /Мэтью Вэлч/, Аудитын хороо /Ж.Жаргалсүрэн/-д даалгасугай.

ТУЗ-ийн ДАРГА



О.БОЛДБААТАР

2019 оны 1 сарын 30 өдөр

№ 19/14

Улаанбаатар хот

Хэлцэл хийх зөвшөөрөл олгох тухай

"ЛэндМН ББСБ" ХК-ийн дүрмийн 9.6.22 дахь заалт, ЛэндМН ББСБ ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн Эрсдэлийн удирдлагын хорооны 2019 оны 1 дүгээр сарын 30-ны өдрийн хурлаас гаргасан зөвлөмж, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2019 оны 1 дүгээр сарын 30-ны ээлжит хурлыг шийдвэрийг түс түс үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Санхүүгийн зохицуулах хорооноос олгосон "Цахим төлбөр тооцоо, мөнгөн гүйвүүлгын үйлчилгээ эрхлэх" түсгай зөвшөөрлийн дагуу 2019 онд Компанийн үйл ажиллагааг өргөжүүлэх, шинээр үйлчилгээ нэвтрүүлэхээр Transfer To Inc-тэй хамтран олон улсын мөнгөн гүйвүүлгын үйлчилгээг эрхлэн явуулахыг зөвшөөрсүгэй.
2. Transfer To Inc-тэй хамтран олон улсын мөнгөн гүйвүүлгын үйлчилгээ эрхлэх, үйл ажиллагааны санхүүжилтийг бий болгохын тулд 1,400,000,000 (нэг тэрбум дөрвөн зүүн сая) хүртэл төгрөгийн үүрэг бүхий хэлцэл хийх эрхийг Компанийн Гүйцэтгэх захирал /Б.Гантулга/-д олгосугай.
3. Олон улсын мөнгөн гүйвүүлгын үйлчилгээг эрхлэн явуулахад холбогдох эрсдэлийг хянаж, зохих түвшинд удирдан ажиллахыг Гүйцэтгэх захирал /Б.Гантулга/-д үүрэг болгосугай.

ТУЗ-ИЙН ДАРГА



О.БОЛДБААТАР